Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлын тэмдэглэл

“Мон-гео” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлыг 2026 оны 04 р сарын 29-ний өдрийн 11:00-цагт өөрийн байранд хуралдуулав.

Оролцсон нь:

Н.Соёмбо- ТУЗ-ийн дарга

М.Алтанцэцэг –ТУЗ-ийн гишүүн

Х.Анар – ТУЗ-ийн гишүүн

Н.Тулга – ТУЗ-ийн гишүүн

Э.Нороврinчин – ТУЗ-ийн гишүүн

Ц.Алтансүх – ТУЗ-ийн гишүүн

М.Адилбиш – ТУЗ-ийн гишүүн

Б.Нямдэлгэр – ТУЗ-ийн гишүүн

Б.Доржмягмар – ТУЗ-ийн гишүүн

А.Ганцэцэг – Гэрээт ня-бо , Ч.Алтансүх , Г.Даваажаргал , Б.Түмэнжаргал ,

Хэлэлцсэн нь :

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангийн талаархи ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэх ,
2. “Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-ийн дүгнэлтийг сонсож хэлэлцэх ,
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдахаар зардлагдсан сонгон шалгаруулалтад оролцох , шаардагдах төсөв, төлөвлөгөө , зардлыг бодитой тооцож тухайн цаг үед нь уялдуулан ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх ,
4. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , санхүүгийн тогтвортой байдлыг хангах ,ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах , гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх ,
5. ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлах компанийн эзэмшлийн 8,08 га газарт үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах төсөл төлөвлөгөөг боловсруулан

хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,түүнчлэн тус газрыг түрээслүүлэх байдлаар үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгах,

6.Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт,мөнгөний ханшийн уналт, инфляцийн тогтворгүй байдалтай уялдуулан "Мон-Гео" ХК-ийн дүрмийн 8.5.1 дэх заалтыг өнөө үетэй зохицуулах замаар өөрчлөн найруулж, шинэчлэн батлах,

7. Компанийн санхүүгийн байдлыг тогтвортой , үр дүнтэй , үр өгөөжтэй болгохоор бизнес төлөвлөгөө,төслийг боловсруулан 2026-2030 онуудад хэрэгжүүлэх гэсэн зүйлүүдийг хэлэлцэх болон компанийн дүрмийн 8.5.1 – дэхь заалтанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд 150,000,000 /нэг зуун тавин сая / төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хэлцэл хийх , зээл авах , гэрээ байгуулах болон компанийн шүүх арбитрт төлөөлөх компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагааг явуулна. 150,000,000 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцлийг ТУЗ-ийн нийт гишүүдийн 2/3 – аас доошгүй зөвшөөрөл авах замаар шийдвэрлэнэ гэсэн байгааг цаг үе инфляцын түвшинд уялдуулан шинэчилж компанийн дүрмийн 8.5.1 дэхь заалтыг ТУЗөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд 300,000,000 / гурван зуун сая / төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хэлцэл хийх, зээл авах , гэрээ байгуулах болон компанийг шүүх арбитрт төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах бөгөөд 300,000,000/ гурван зуун сая/ төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ хэлцлийг ТУЗ-ийн нийт гишүүдийн 3/2- оос зөвшөөрөл авах замаар шийдвэрлэнэ гэж өөрчлөн шинэчилэх шаардлагатай байгаа талаар гүйцэтгэх захирал танилцууллаа.

Хурлын дарга ирцийн мэдээг танилцуулав. Үүнд : Гол хувьцаа эзэмшигч 1.Н.Соёмбо- Хувьцааны тоо – /35544/ , брокер нэр – /Дархан брокер/ , 67,6 хувь

2.Ц.Алтансүх – Хувьцааны тоо - /10360 /, брокер нэр - /Аргай бест / , 19,7 хувь хувьцаа эзэмшигч нар ирсэн байна. Хурлын ирц 100% байна. Хурлын үйл ажиллагааг эхлүүлье гэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга хурлын дэгийг сонсголоо. Хурлыг 11 цагт эхэлж 14 цагт дуусгана.

А.Ганцэцэг : 2025 жилийн санхүүгийн тайланг сонсголоо. Тэрээр 2025 онд тус компани алдагдалтай ажилласан ба татварын хувьд нилээдгүй өртэй байна. Үүнээс нийт хөрөнгийн өгөөж ЭӨ /Балансын нийт дүн : 563,8 / 654,8 = 0.86 , Өөрийн хөрөнгийн өгөөж ЦЭХ / Нийт : ЭӨДүн 42,4 / 91,1 =0,46 ,Түргэн хөрвөх чадварын харьцаа :ЭХ / БХӨТ – ын дүн 42,4 / 91,1 =0,46 байна. Энэ үзүүлэлт нь компанийн санхүүгийн төлбөрийн чадварын хувь бага байгааг илэрхийлж байна гэж танилцууллаа.

М.Алтанцэцэг – 2025 оны компанийн үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Компанийн үйл ажиллагааны тайланг батлагдсан маягтын дагуу тайлагналаа. Өнгөрсөн 2024 онтой харьцуулахад онцын өөрчлөлт гараагүй байна.Үйл ажиллагаанд нөлөөлсөн хүчин зүйлгүй байгааг тэмдэглэв. Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон гаргасан хувьцаагүй болно. Мөн хурлаар хэлэлцэх асуудлуудыг дэлгэрэнгүй танилцууллаа.

Хурлын дарга : За та бүхэн компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудыг сонсож , хурлаар хэлэлцэх асуудлуудтай танилцацгаалаа. Одоо санал шүүмжлэлдээ орьё.

А.Ганцэцэг : Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангуудтай танилцлаа. Одоо ТУЗ-ийн гишүүн та бүхний шинэ сэргэг санаа оноо , үйл ажиллагаа хэрэгтэй байна. Санхүүгийн хувьд алдагдалтай ажиллаж байгаа дээр гол анхаарлаа төвлөрүүлж ажиллацгаая. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авна.

М.Алтанцэцэг : Бид жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуулийн хугацаанд хийж байна. Санхүүгийн чадамжаа сайжруулах , компани мөнгөн урсгалтай болохын тулд өөрсдийн нөөц боломжоо ашиглан , бизнес төлөвлөгөөгөө хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Тодорхой зүйл дээр төвлөрч , үүргээ хэрэгжүүлэн ажиллаж чадвал бид санхүүгийн хувьд чадамжтай ,алдагдалгүй ажиллах нөхцөл бүрдэх байхаа гэж харж байна. Хурлаас гарах шийдвэрийг хүндэтгэн хүлээн авч хэрэгжүүлэн ажиллахад чармайлт гарган ажиллана. Дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна.

Н.Соёмбо : Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан , аудиторын дүгнэлтэд тулгуурлан гишүүн бүр санаа оноогоо танилцуулж хэрхэн ажиллахаа ярилцаарай. Ээлжит хурлаас гарах шийдвэрүүд үйл ажиллагаанд чухал байдаг.

Э.Нороврinчин: 2025 оны компанийн тайлангуудтай танилцлаа. Аудиторын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй юм байна. Цаашид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , дорвитой үр өгөөжөө өгөх төсөл,төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэн ажиллъя. Хүн бүрийн хүчин чармайлт чухал хэрэгтэй байна гэдгийг хэлье. Хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авна . Өнөө үетэйгээ уялдуулан өөрчлөх дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна.

Х.Анар : Үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг сонсож танилцлаа. Компани үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлэх тал дээр тодорхой зорилтод ажлуудыг хийж хэрэгжүүлэх төлөвлөгөө төслийг боловсруулж үр дүнг нь харж санхүүгийн чадамжийг чадавхжуулж үйл ажиллагаагаа яаралтай өргөжүүлж тодорхой төлөвлөгөө зорилт тавин ажиллах нэн шаардлагатай байна . Компанийн удирдлагууд энэ асуудлыг анхааралдаа авч холбогдох ажлыг зохион байгуулна гэж бодож байна. Компанийн дүрмийн өөрчлөлт болон холбогдох бусад ажлыг дэмжин хамтарч ажиллахаа мэдэгдэж байна.

Б.Доржмягмар : Компанийн 2025 оны ажлын тайлангуудыг сонсож мэдлээ. Хамгийн түрүүнд компанийн санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажиллах шаардлагатай. Үүний тулд компанийн үйл ажиллагааны чиглэлд тулгуурлан төсөл, төлөвлөгөө хэрэгжүүлэх хэрэгтэй.Геологи ,уул уурхай ,барилга руу чиглэсэн төсөл ,бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллавал яасан юм бэ. Ямар нэгэн судалгаа төсөл , төлөвлөгөө хэрэгжүүлэн ажиллахад татгалзах зүйлгүй. Эдийн засагч хүний хувьд дэмжин ажиллана. Ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авна.

Б.Нямдэлгэр : Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Ойрын хугацаанд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөгөө боловсруулан шат дараалан хэрэгжүүлэх ажилдаа хугацаа алдалгүй орцгооё.Үүний үр дүнд санхүүгийн хувьд алдагдалгүй ажиллах болно гэж бодож байна. Шийдвэрүүдийг хүлээн авна хамтарч ажиллах болно. Компанийн дүрмийн өөрчлөлтийг дэмжинэ.

Н.Тулга : Тайлангуудтай танилцлаа. Бизнес төлөвлөгөөг сайн боловсруулж хэрэгжүүлэн ажиллъя. Татварын өр ,санхүүгийн хувьд алдагдалтай байгааг таслан зогсоох нь бидний үүрэг. Иймд төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад хүчин чармайлт гарган ажиллах болно гэдгээ илэрхийлье. Компанийн дүрмийн өөрчлөлтийг болон хурлаас гарах шийдвэрүүдийг хүлээн авч , идэвхи гарган ажиллана.

Ц.Алтансүх : Тайлангуудыг сонсож мэдлээ. Бидний гол зорилго санхүүгийн алдагдлыг багасгах , бүр алдагдалгүй ажиллаж байх ёстой.Оновчтой цаг үеэ мэдэрсэн бизнес төлөвлөгөө , төслийг судалгаан дээр тулгуурлан боловсруулж шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай юм байна гэж харагдаж байна. Миний бие уг бизнес төлөвлөгөөг боловсруулахад идэвхтэй оролцох болно. Хурлаас гарах шийдвэрийг хүлээн авна. Дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна.

М.Адилбиш : Компанийн тайлангуудын болон аудитын дүгнэлттэй танилцлаа. Хамгийн тулгамдсан асуудал нь үндсэн үйл ажиллагаагаа явуулах , өргөжүүлэх , санхүүгийн чадамжаа сайжруулах л байна. Иймд бизнес төлөвлөгөөгөө сайн боловсруулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч байгаа нь харагдаж байна. Үүний тулд ажиллана гэж хэлэх байна. Хурлын шийдвэрийг хүлээн авна. Дүрмийн өөрчлөлтийг дэмжиж байна.

Н.Соёмбо: Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцлаа. Цаашдаа бид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай . Үйл ажиллагааны чиглэлээ зах зээлийн хуулиар зохицуулан нэмэгдүүлэх, үр өгөөжтэй санхүүгийн байдлыг үр дүнтэй болгох бизнес төлөвлөгөө боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлуудыг хийх шаардлагатай байна. ТУЗ-ийн гишүүд , удирдлага хамтран нөөц бололцоо чадамжаа ашиглан ажиллъя.

Хурлаас зохих шийдвэрүүдийг гаргана. Зах зээлийн өнөө үетэй , мөнгөний уналт , инфляцын түвшинг харгалзан компанийн дүрмийн заалтыг өөрчлөх нь зүйтэй, дэмжиж байна. гэснээр хурлын санал шүүмжлэлийг тасаллаа.

Шийдвэрлэсэн нь :

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангийн талаархи ТУЗ-ийн хурлын шийдвэрийг батлахаар,.
2. “Шинэ Их Тэрбум Аудит” ХХК-ийн дүгнэлтийг батлахаар,
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зохион байгуулагдахаар зардлагдсан сонгон шалгаруулалтад оролцох , шаардагдах төсөв, төлөвлөгөө , зардлыг бодитой тооцож тухайн цаг үед нь уялдуулан ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлж батлахаар,
4. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх , санхүүгийн тогтвортой байдлыг хангах , санхүүгийн тогтвортой байдлыг хангах ,ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах , гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөхөөр,

5. ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлах компанийн эзэмшлийн 8,08 га газарт үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах төсөл төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,түүнчлэн тус газрыг түрээслүүлэх байдлаар үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгахаар,

6.Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт,мөнгөний ханшийн уналт, инфляцийн тогтворгүй байдалтай уялдуулан “Мон-Гео” ХК-ийн дүрмийн 8.5.1 дэх заалтыг өнөө үетэй зохицуулах замаар өөрчлөн найруулж, шинэчлэн батлахаар,

7. Компанийн санхүүгийн байдлыг тогтвортой , үр дүнтэй , үр өгөөжтэй болгохоор бизнес төлөвлөгөө,төслийг боловсруулан 2026-2030 онуудад хэрэгжүүлж батлахаар тус тус шийдвэрлэлээ. Хурлыг 14:45 цагт дуусгав.

Тэмдэглэл хөтөлсөн ..... / Х.Анар /